



ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/201

Улиастай

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.10, “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг зарцуулах журам”-ийн 4 дүгээр зүйл 4.1.8, аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 4 дүгээр бүлэг 4.22.5 дахь заалтыг үндэслэн 2017 онд Батлан хамгаалахын сайдын аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг хангах зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, бүрэн дунд сургуулийн сурагчдыг цэрэг-эх оронч үзэлтэй, бие бялдар, сэтгэл зүйн өв тэгш хүмүүжилтэй иргэн болгон төлөвшүүлэх зорилтын хүрээнд бүрэн дунд сургуулийн 11 дүгээр ангийн сурагчдын дунд аймгийн аврага шалгаруулах “Дөл” тоглолтыг 2017 оны 05 дугаар сарын 19-нд зохион байгуулан явуулсугай.

2. Тоглолтыг зохион байгуулан явуулахад шаардагдах 2.593.670 /Хоёр сая таван зуун ерэн гурван мянга зургаан зуун далан төгрөг/-ийг хавсралтаар баталж, цэргийн мөнгөн төлбөрийн орлогоос гаргахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Ж.Хүрэлбаатар/-т зөвшөөрсүгэй.

3. Тоглолтыг зохион байгуулан явуулах бүх талын арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб /дэд хурандаа Г.Нэмэхбаяр/-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтэс /Н.Бямбадорж/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАТСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/201 захирамжийн хавсралт

ДӨЛ ТОГЛОЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАН ЯВУУЛАХАД ШААРДАГДАХ  
ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зарцуулах төсөв /төг/	Дүн /төг/	Тайлбар
1	Өргөмжлөл	3*20000	60.000	
2	Медаль	39*4000	156.000	
3	Мөнгөн шагнал	1-р байр 200.000 2-р байр 150.000 3-р байр 100.000	450.000	
4	Сумдын сургуулиудаас оролцох бүрэлдэхүүнийг тээвэрлэх автомашины ШТМ-ын зардал	А80 Идэр 20л*156км=31,8л*1650=52470 Их-Уул Тосонцэнгэл 20л*448км=91,4л*1650=150810 Тэс 20л*362км=73,8л*1650=121770 20л*602км=122,8л*1650=202620	527.670	
5	Орон нутгаас ирэх сургуулиудын бүрэлдэхүүнийг байрлуулах зардал	Байр: 150000*4	600.000	
6	Есөн хөлт цагаан тугын байрны хурдаас солих	60м2*10000	600.000	
7	Бусад зардал	200000	200.000	
<b>Дүн</b>			<b>2.593.670</b>	

ЦЭРГИЙН ШТАБ